

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР №25

Хуралдаан 2013 оны 9 дүгээр 12-ны өдрийн 14 цаг 10 минутад эхэлж, 15 цаг 26 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 16 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Технологи нэвтрүүлэх хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Цөмийн энергийн газрын Технологи нэвтрүүлэх хэлтсийн даргын албан тушаалд Батболдын Мөнхтөрд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Цөмийн энергийн газрын дарга Н.Тэгшбаярт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Хүний Эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны даргын албан тушаалд уг албан тушаалын нөөцөөс А.Дашдэлэгийг томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Александрын Дашдэлэгийг Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын

		албаны даргын албан тушаалд томилуулахаар төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөөс нэр дэвшүүлэн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадоржид санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай /Д.Ууганбаатарыг төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөөс хасах/	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. “Нөөцийн жагсаалтад бүртгэх, нэр дэвшүүлэх тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 31 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн “сонгон шалгаруулалтанд орж тэнцсэн” гэсний дараах “Доржготовын Ууганбаатар” гэсэн нэрийг хассанд тооцох.</p> <p>2. Энэ тогтоолыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, иргэн Д.Ууганбаатар нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	УИХ-ын даргын Хууль зүйн бодлогын зөвлөхөөр ажиллаж байсан Л.Өлзийсайханыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөхөөр 2012 онд томилогдон ажиллаж байсан Лувсандоржийн Өлзийсайханыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>

5	Говьсүмбэр аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	<p>Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баянжаргалын 2013 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 272 тоот албан бичиг, Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 10 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтлоо.</p>
6	<p>Бусад асуудал:</p> <p>- Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>Нэг. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган, төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 10 төрийн албан хаагчийг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах:</p> <ol style="list-style-type: none"> 1. Адъяасүрэн Чимэддаваагийн -Төв аймгийн Татварын хэлтсийн Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, 2. Батжаргал Батсүхийн -Төв аймгийн Өндөрширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, 3. Батжаргал Гүрдагвын -Төв аймгийн

		<p>Тээвэр, авто замын газрын дарга, 4. Ганчимэг Сангирагчаагийн -Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга, 5. Намбар Дэчингийн -Төв аймгийн Зуунмод сумын Нэг цонхны йлчилгээний нотариатч, 6. Нарантуяа Цэрэнжамцын -Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэр-гэжилтэн, 7. Сүхбаатар Цэвээний -Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Татварын улсын байцаагч, 8. Түмэндэмбэрэл Лувсандоржийн -Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч, 9. Үзмээ Равдандоржийн -Төв аймгийн Зуунмод сумын Номт багийн зохион байгуулагч, 10. Энхтунгалаг Сосорбарамын -Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Даатгал, нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч</p> <p>Хоёр. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу тухайн байгууллагаас олгох.</p> <p>Гурав. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

